



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 23

№ 01/53 ДУА-2018/09/СТА-ТЧЗ Мандалговь хот

Г

7

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Эрүүл мэндийн газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аudit хийх явцад **5,518,039.00** /Таван сая таван зуун арван найман мянга нэг зуун гучин есөн/ төгрөгийн дараах зөрчлүүд илрэлээ. Үүнд:

1. Хичээл практикийн зардлаас сургалтын цай, хоолны зардалд **5,221,020.00** /Таван сая хоёр зуун хорин нэгэн мянган хорин/ төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/ мөн Монгол улсын Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 147 дугаар тогтоолын 3.7-д /Хурал, сургалт, зөвлөлөөний давтамжийг багасгах, зайлшгүй хийх тохиолдолд төлөөлөгчийн тоог цөөн, оновчтой, богино хугацаанд хийхээр эсхүл цахим хэлбэрээр зохион байгуулах/ тус тус заасныг;

2. Мэргэжил дээшлүүлэх сургалтад суралцаж байгаа албан хаагчид **297,019.00** /Хоёр зуун ерин долоон мянган арван есөн/ төгрөгийн үр дүнгийн урамшуулал, цалингийн нэмэгдлийг олгосон.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27.1.9-т /Төрийн хөрөнгөөр давтан сурх, мэргэшлээ дээшлүүлэх, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалынхаа цалин хөлсийг авах/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомжс, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зорчлийг арилгуулах зорилгоор толборийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хорөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зорчсон/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

- Төсвийг үр ашигтай зарцуулан, хэмнэлтийн горимыг баримтлаж ажиллах;
- Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Эрүүл мэндийн газрын төсвийн шууд захирагч Г.Бат-Орших, нягтлан бодогч Ч.Бямбаа нарт хариуцуулав.


### АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

ЗӨВШӨӨРСӨН:

АУДИТОР  Т.ОЮУН-ЭРДЭНЭ

4817144213  
ЗЮА0039 0033475

ДАРГА  Г.БАТ-ОРШИХ  
НЯГТЛАН БОДОГЧ  Ч.БЯМБАА

9034064 x 4816129119

---

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.